

**ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР**
Санхүүгийн аудитын алба



ЭРСДЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**“Төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, хяналт
тавих тухай хууль, тогтоомжийн хэрэгжилт”-д
хийсэн аудитын тайлан**

АУДИТЫН КОД: ДОО -2020/01/-ЭА

Чойбалсан хот 2020 он



Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд Тэргүүлэх аудитор Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер В.Цэнгэлмаа
Утас: 7058-4204, Цахим хаяг: tsengelmaav@audit.gov.mn
Ахлах аудитор Д.Нармандах
Аудитор Б.Одхүү
Утас: 7058-4207, Цахим хаяг: odkhuub@audit.gov.mn
Аудитор Ж.Баяртуул
Утас: 7058-4207, Цахим хаяг: bayartuulj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтийн товъёг	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	5
БҮЛЭГ 1.ТӨРД УЧИРСАН ХОХИРЛЫГ НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ ТАЛААР ЭРХ ЗҮЙН ОРЧИН БҮРДСЭН Ч ТӨРД УЧИРСАН ХОХИРЛЫГ БҮРЭН ТООЦООГҮЙ БАЙНА.	6
БҮЛЭГ 2. ТӨРД УЧРУУЛСАН ХОХИРЛЫН БАРАГДУУЛАЛТ 20.1 ХУВЬТАЙ БАЙНА.....	7
БҮЛЭГ 3. ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛД ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛИЙН 50.1, 50.2 ДАХЬ ЗААЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛААР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ БАЙХГҮЙ БАЙНА.....	9
Холбогдох байгууллагын санал:	12
Саналд өгсөн тайлбар:	12
ДҮГНЭЛТ:	13
ЗӨВЛӨМЖ:	15
ТУШААЛ:	17

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ЗЕХ	Захиргааны ерөнхий хууль
ДОА	Дорнод аймаг
ЭА	Эрсдэлийн аудит
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
СХАА	Санхүүгийн хяналт, аудитын алба
ХХҮГ	Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар
ЭМТ	Эрүүл мэндийн төв

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Төрөөс олгуулахаар шийдвэрлэсэн хохирлын хэмжээ	7
Дүрслэл 2	Төрд учруулсан хохирлын хэмжээ	7
Хүснэгт 1	Төсөвт буцаан төвлөрүүлэх хохирлын дүн	8

**Аудит хийх
үндэслэл, бүрэн
эрх****Аудитын зорилт****Аудитын хамарсан
хүрээ****Аудитын арга зүй,
шалгуур үзүүлэлт****Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа****Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх
мэдэгдэл**

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2019 оны 05 дугаар тогтоол, “Аудитын төлөвлөгөө батлах тухай” Монгол Улсын Ерөнхий аудиторын 2019 оны А/100 дугаар тушаалаар батлагдсан сэдвийн дагуу, Төрийн аудитын тухай хуулийн 15.2-д заасан Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

“Төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, хяналт тавих тухай хууль, тогтоомжийн хэрэгжилт”-д эрсдэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулан, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Төрд учирсан хохирлыг хууль тогтоомжийн дагуу тооцсон эсэх
- Төрд учирсан хохирлыг хууль тогтоомжийн дагуу буруутай албан тушаалтнаар төлүүлсэн эсэх
- Хохирлыг нөхөн төлүүлэх талаар холбогдох байгууллагууд хяналт тавьж ажилласан эсэх

Аудитад шүүхээс 2017-2019 онд Дорнод аймгийн төрийн захиргааны байгууллагын албан тушаалтны буруутай үйл ажиллагааны улмаас 19 хариуцагчтай 84.5 сая төгрөгийг төрөөс олгуулахаар шийдвэрлэсэн шийдвэрүүдийг хамрууллаа.

Аудитыг гүйцэтгэхдээ Гүйцэтгэлийн аудитын удирдамж, (АДБОУС 3000-3100, Гүйцэтгэлийн аудитын гарын авлага, журамд заасны дагуу холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, тайлбар, тодруулга авах, шалгадагч байгууллагаас авсан судалгаа, мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, тулган баталгаажуулах, анхны баримтаас хөөн шалгах, ажиглалт хийх зэрэг аудитын горимуудыг ашиглав.

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор Б.Болортуул удирдаж, үе шатны болон чанарын хяналтыг аудитын менежер В.Цэнгэлмаа хэрэгжүүлж, гүйцэтгэлийн аудитын албаны ахлах аудитор Д.Нармандах, аудитор Б.Одхүү, Ж.Баяртуул нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Аудитын талбарын ажлыг 2020 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлүүлж, тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл болон Санхүү хяналт аудитын албанд 2020 оны 06 дугаар сарын 15-ны өдөр хүргүүлээ.

Төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар эрх зүйн орчин бүрдсэн ч төрд учирсан хохирлыг бүрэн тооцоогүй байна.

Төрд учирсан хохирлыг гэм буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх талаар 2016 оны 07-р сарын 01-ээс хэрэгжиж эхэлсэн Захиргааны ерөнхий хуульд зааж өгсөн.

Уг хуулийн 103.1, 103.2, 103.3 дахь заалтуудаар Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас захиргааны байгууллагад учирсан хохирлыг гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлэх харилцааг зохицуулсан.

Дээрх зохицуулалтаар захиргааны байгууллагад учирсан хохирлыг гэм буруутай албан тушаалтнаар төлүүлэх үүргийг дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгжид, дотоод аудитын нэгж байхгүй бол Төрийн аудитын байгууллагад хариуцуулсан байна.

Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1-д “Төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ”, 50.2-д “Төрийн албаны төв байгууллага шүүхийн шийдвэрийн биелэлтийн талаар бүртгэл хөтөлж, төрд учруулсан хохирлын нөхөн төлөлтөд хяналт тавьж, нөхөн төлөгдөөгүй тохиолдолд төрийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргана” гэж заасан.

Орон нутгийн хувьд салбар зөвлөл нь Төрийн албаны зөвлөлийн чиг үүргийг хэрэгжүүлэгч бөгөөд Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор салбар зөвлөлийн ажиллах журмыг шинэчлэн баталсан байна.

Уг журмын нийтлэг үндэслэлийн тухай 1 дүгээр зүйлийн 1.2-т “Салбар зөвлөл нь Төрийн албаны зөвлөлийн зохион байгуулалтын бүтцийн нэгж бөгөөд Төрийн албаны тухай хууль, Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм, холбогдох бусад журам, дүрэмд заасан чиг үүргийг Төрийн албаны зөвлөлийн бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлнэ” гэж заасан байна. Мөн салбар зөвлөлийн хэрэгжүүлэх чиг үүргийн тухай 3 дугаар зүйлийн 3.4.3-т “төрийн нэрийн өмнөөс шүүхэд нэхэмжлэл гаргах санал Төрийн албаны зөвлөлд хүргүүлэх, энэ талаар зохих арга хэмжээг авах”, 3.6.4-т “Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих” гэж заасан байна.

Эдгээр заалтуудын хүрээнд төрд учирсан хохирлыг бураатай албан тушаалтнаар төлүүлэх талаар үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчин бүрдсэн байна.

Дорнод аймгийн хэмжээнд 2017-2019 онуудыг хамаарах төрийн нэрийн өмнөөс төсвөөс төлсөн нийт 71.5 сая төгрөгийн хохирол гарсан байна. Үүнээс 70.2 сая төгрөг нь үндэслэлгүй ажлаас халагдсан иргэнд олгосон ажилгүй байсан хугацааны нөхөн олговор, 1.3 сая төгрөг нь хариуцагчаар төлүүлэхээр шийдвэрлэгдсэн тэмдэгтийн хураамж байна.


Захиргааны байгууллагууд нь иргэнд олгосон ажилгүй байсан хугацааны нөхөн олговрыг төрд учирсан хохирлоор тооцож 60 хувьд нь хохирол тооцож, төлүүлэх

талаар үйл ажиллагаа хэрэгжүүлсэн байгаа ч тэмдэгтийн хураамжийг хохиролд тооцох тухай асуудал орхигдсон байна.

Төрд учруулсан хохирлын барагдуулалт 20.1 хувьтай байна.

Дорнод аймгийн төсвийн байгууллагуудын хэмжээнд 2017-2019 онд 21 иргэнийг ажлаас үндэслэлгүй халсан, чөлөөлсөн шийдвэрийг хүчингүй болгуулж, үүрэгт ажилд эргүүлэн томилуулах, ажилгүй байсан хугацааны олговрыг гаргуулахаар шүүхэд хандсанаас 19 шийдвэр нэхэмжлэгчийн талд гарч, 1 хариуцагчийн талд, 1 иргэнтэй эвлэрлийн гэрээ байгуулсан байна.


Дүрслэл №1, Төрөөс олгуулахаар шийдвэрлэсэн хохирлын хэмжээ /сая төгрөг/



Шүүхээс 2017-2019 онд Дорнод аймгийн төрийн захиргааны байгууллагын албан тушаалтны буруутай үйл ажиллагааны улмаас 19 хариуцагчаар 84.5 сая төгрөгийг төрөөс олгуулахаар шийдвэрлэсэн байна.

Шүүхийн шийдвэрийг үндэслэн 1 иргэний 2.5 сая төгрөгийн хохирлыг буруутай албан тушаалтан өөрөө барагдуулж, 14 иргэнд 70.2 сая төгрөгийг төрийн нэрийн өмнөөс 15 захиргааны байгууллага төсвөөс олгосон байна.

Дүрслэл №2, Төрд учруулсан хохирлын хэмжээ /сая төгрөг/



Мөн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1-д “Шүүхийн зардлыг нэхэмжлэл бүрэн хангагдсан тохиолдолд хариуцагчаар, нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон тохиолдолд нэхэмжлэгчээр нөхөн төлүүлнэ” гэж

заасны дагуу хариуцагчаар төлүүлэхээр шийдвэрлэгдсэн тэмдэгтийн хураамжид төсвөөс 1.3 сая төгрөгийг зарцуулсан байна.

Төрд учирсан хохирлыг буцаан төлүүлэх нэхэмжлэл гаргасан нь шүүхээр шийдвэрлэгдсэн бол ЗЕХ-ийн 103 дугаар зүйлийн 103.4-д “Гомдлыг хянан шийдвэрлэсэн дээд шатны захиргааны байгууллага болон шүүх хохирлыг буруутай албан тушаалтнаар төлүүлэхээр гаргасан актын хувийг холбогдох аудитын байгууллагад хүргүүлэх үүрэгтэй” гэж заасан байна.

Дорнод аймгийн хэмжээнд 2017-2019 онд төрд учирсан хохирлыг гэм буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх талаар нэхэмжлэл шүүхэд ирээгүй байна.

Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ”, 103.2-т “Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна” гэж заасан байна.

Төсөвт буцаан төлүүлэх 57.1 сая төгрөгийн хохирлоос 45.3 сая төгрөг нь аймгийн ТЕЗ-ийн дотоод аудитын нэгжид, 11.8 сая төгрөг нь улсын төсөвт байгууллагуудын ТЕЗ-дийн дотоод аудитын нэгжид хамаарахаар байна.

Хүснэгт №1. “Төсөвт буцаан төвлөрүүлэх хохирлын дүн” /төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Улсын төсвийн байгууллага	Орон нутгийн төсвийн байгууллага
2017 он			
1	Дорнод Их сургууль	2,458,970.00	
2	Стандарт, хэмжил зүйн хэлтэс	6,239,650.00	
3	ХХҮГ	3,074,079.00	
4	10 дугаар цэцэрлэг		1,441,369.00
5	Баянтүмэн ЭМТ		5,963,849.00
Дүн		11,772,699.00	7,405,218.00
2018 он			
1	Матад сумын ЗДТГ		5,477,100.00
2	Баян-Уул сумын ЗДТГазар		6,868,956.00
3	Дашбалбар соёлын төв		1,781,939.00
4	Баянтүмэн ЭМТ		7,986,799.00
5	Хөлөнбуйр сумын цэцэрлэг		3,211,500.00
6	Гурванзагал сумын ЗДТГ		6,319,395.00
7	Гурванзагал сумын ЗДТГ		5,000,000.00
8	Улсын тэмдэгтийн хураамжид		1,300,000.00
Дүн		-	37,945,689.00
Нийт дүн		11,772,699.00	45,350,907.00

Санхүүгийн хяналт, аудитын алба нь 45.3 сая төгрөгийн хохирлоос 2017-2019 онд гүйцэтгэсэн хяналт шалгалтын ажлуудын хүрээнд 13.6 сая төгрөгийг буцаан төлүүлэхээр төлбөрийн акт тогтоож, 14.7 сая төгрөгийг буруутай албан тушаалтнаас нэхэмжлэх тухай албан тоотыг тухайн байгууллагад хүргүүлсэн байна.

Харин хяналт шалгалтад хамрагдаагүй байгууллагуудын 15.7 сая төгрөгийн хохирол болон тэмдэгтийн хураамжид орон нутгийн төсвөөс төлсөн 1.3 сая төгрөгийг буцаан төлүүлэх асуудал орхигдсон байна.

Улсын төсөвт байгууллагуудын ТЕЗ-чдад хамаарах 11.8 сая төгрөгийн хохирлыг төсөвт буцаан төлүүлэх ажилбар огт хийгдээгүй байна.

Аймгийн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд төрд учруулсан хохирлын талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ байхгүй байна.

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл нь шүүхийн шийдвэрийн талаар бүртгэл хөтөлдөггүй, ирүүлсэн өргөдлийн хүрээнд асуудлыг шийдвэрлэдэг байна. Энэ нь Дорнод аймаг дахь салбар зөвлөлөөс авсан ярилцлага, тодруулгаар нотлогдож байгаа бөгөөд Дорнод аймгийн салбар зөвлөлд 2017-2019 онд ажлаас халагдсан асуудалтай холбоотой 2 албан хаагч өргөдөл гаргасан нь Төв байгууллага болон шүүхээр шийдвэрлэгдсэн байна.

Аудитын явцад Шүүхийн тамгын газар, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл, Санхүүгийн хяналт, аудитын алба, төрийн байгууллагуудаас авсан нотлох баримт, судалгаагаар эдгээр байгууллагуудын хооронд мэдээлэл солилцох талаар гарсан заавар, журам байхгүй байна.

Шүүхээс ажилгүй байсан хугацааны нөхөн олговор олгохоор шийдвэрлэсэн 11.8 сая төгрөгийг иргэнд олгоогүй байгаа бөгөөд 6.1 сая төгрөг нь орон нутгийн төсвөөс, 5.7 сая төгрөг нь улсын төсвөөс олгогдохоор байна.

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд төрийн албаны тухай хуулийн 50.1, 50.2 дахь заалтыг хэрэгжүүлэх талаар зохион байгуулсан арга хэмжээ байхгүй байна.

Гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг барагдуулах тухай Захиргааны ерөнхий хуулийн 103.1¹, 103.2², 103.3³, болон Төрийн албаны тухай хуулийн 35.1.2⁴, 50.2⁵ дахь заалтуудаар хяналт тавих үйл ажиллагааг зохицуулсан байна.

1 "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ"

2 "Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна"

3 103.3-т "Энэ хуулийн 103.2-т заасан дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж байхгүй бол гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг төрийн аудитын байгууллага хариуцна"

4 аудитын хамрах хүрээний 2017-2018 оныг дуустал мөрдөгдөж байсан Төрийн албаны тухай хуулийн 35.1.2-т "Төрийн албаны тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах, төрийн албанд шударга ёсны зарчмыг хэрэгжүүлэх мэргэшил, арга зүйн удирдлагаар хангах, төрийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулсан стандартын хэрэгжилтийг шалган зааварлах, зөрчлийг арилгуулах хугацаатай үүрэг өгөх, гүйцэтгэлд нь хяналт тавих, энэ хуулийн 39.1-д заасан маргааныг хянан шийдвэрлэх, албан тушаалтны буруутай үйл ажиллагаанаас төрд учруулсан хохирлыг арилгуулахаар төрийн нэрийн өмнөөс шүүхэд нэхэмжлэл гаргах"

5 2019 оны 1 дүгээр сараас эхлэн мөрдөгдөж буй Төрийн албаны тухай хуулийн 50.2-т "Төрийн албаны төв байгууллага шүүхийн шийдвэрийн биелэлтийн талаар бүртгэл хөтөлж, төрд учруулсан хохирлын нөхөн төлөлтөд хяналт тавьж, нөхөн төлөгдөөгүй тохиолдолд төрийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргана"

Дорнод аймгийн хэмжээнд ТЕЗ-ийн хамрах хүрээний төсвийн 13 байгууллагын 13 төрийн албан хаагчийг хууль бусаар ажлаас халсан 13 удаагийн шүүхийн шийдвэр гарсан байна.

Санхүүгийн хяналт, аудитын алба нь орон нутгийн төсөвт байгууллагын үйл ажиллагаанд 2 жил тутам нэгээс доошгүй удаа төлөвлөгөөт хяналт шалгалт хийж, мөн шаардлагатай тохиолдолд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийдэг байна.

Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2017-2019 онд эдгээр 13 шийдвэрээс 7 шийдвэрт холбогдох 28.3 сая төгрөгийн хохирлыг барагдуулах төлбөрийн акт болон албан тоотыг төсвийн захирагчдад хүргүүлж, 6 шийдвэртэй холбоотой 15.7 сая төгрөгийн хохирлын асуудалд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Аудитын явцад дээрх 15.7 сая төгрөгийн хохирлыг 2020 оны хяналт шалгалтад хамруулан, асуудлыг шийдвэрлэж байгаа гэсэн үндэслэлтэй тайлбарыг ирүүлсэн бөгөөд төрд учирсан хохирлыг буцаан төлүүлэх асуудлаар тухайлан хяналт хэрэгжүүлдэггүй, төлөвлөгөөт хяналтын ажлын дэд асуудал болгон шийдвэрлэж байгаа нь хохирлыг төсөвт төвлөрүүлэх ажлын үр нөлөөг бууруулж байна.

Санхүүгийн хяналт, аудитын албанаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилт дараах байдалтай байна. Үүнд:

- Хүргүүлсэн албан тоотын дагуу 14,701.6 мянган төгрөгийг буруу шийдвэр гаргасан төрийн албан хаагчаар төлүүлэх талаар Баянтүмэн сумын ЗДТГ нь шүүхэд гаргасан нэхэмжлэлээ хариуцагч нь Япон улсад сурч байгаа тул хариуцагчийг ирсэн үед дахин нэхэмжлэхээр шийдвэрлэн татан авсан байна.
- Төрд учирсан хохирлыг барагдуулахаар тогтоосон 13,627.7 мянган төгрөгийн төлбөрийн актын төлөх хугацаа дууссан тул Прокурорын байгууллагын тухай хуулийн 20.1⁶ дэх заалтын дагуу аймгийн Прокурорын газартай байгуулсан санамж бичгийн хүрээнд хэрэгжилтийг хангуулахаар шилжүүлсэн байна.

Захиргааны ерөнхий хуулийн 103.3 дахь заалтын дагуу Төрийн аудитын байгууллага нь 2017-2019 онуудад улс болон орон нутгийн төсөвт байгууллагуудад санхүүгийн тайлангийн аудитын хамрах хүрээнд 3 байгууллагын төрд учирсан хохирлыг барагдуулах тухай албан шаардлагыг аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанд хүргүүлсэн.

Мөн 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар төрийг хохиролгүй болгох тухайд тогтоосон 1.7 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосон нь бүрэн хэрэгжсэн бөгөөд, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүлсэн. Уг зөвлөмжийн тухайн байгууллага 2019 онд төсвөөс төлсөн 10.8 сая төгрөгийн хохирлыг буруутай албан тушаалтнаар бүрэн төлүүлсэн байна.

⁶ “Прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлт, эсхүл өөрийн санаачилгаар захиргааны болон иргэний хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигчоор, эсхүл гуравдагч этгээдээр оролцоно”

Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2020 оны 6 дугаар сарын 01-нээс мөрдөгдөж эхэлсэнтэй холбоотойгоор тус хуулийн 36.1⁷ дэх заалтын дагуу мэдээллийн сан үүсгэн ажиллаж эхлээд байна.

Аймгийн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд Төрийн албаны тухай хуулийн 50.1, 50.2 дахь заалтыг хэрэгжүүлэх талаар зохион байгуулсан арга хэмжээ байхгүй байна.

ТЕЗ-ийн хамрах хүрээнээс бусад улсын төсөвт байгууллагуудын 2017-2019 онуудад 3 байгууллагын 5 төрийн албан хаагчийг хууль бусаар ажлаас халсантай холбоотой 11.8 сая төгрөгийн хохирлыг төрөөс төлөх тухай шүүхийн шийдвэрүүд гарсан байна. Дээд шатны байгууллагын дотоод аудитаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар эрх зүйн орчин бүрдсэн ч хууль, тогтоомжийн заалтууд бүрэн хэрэгжихгүй байгаа нь хуулийг хэрэгжүүлэх байгууллагууд нэгдсэн нэг мэдээлэл, арга зүй, ажлын уялдаа дутмаг байгаатай холбоотой байна.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:

Р. Утсгалант
Мамияаг, Аудитын тухай хууль
5/19

ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБА
Дорнод аймаг, Хэрлэн сум, 10 дугаар баг
Засаг даргын Тамгын газрын 3 дугаар байр
Утас/факс: 7058-3168
Sankhuu_audit_dor@yandex.com

Хяналт № 115
Тайлбар № 885

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Б.БОЛОРТУУЛ ТАНАА

Төрийн аудитын газраас "Төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, хяналт тавих тухай хууль тогтоомжийн хэрэгжилт"-д хийсэн эрсдэлийн аудитын тайлангийн төслийг хүлээн авч танилцлаа.

Уг тайлангийн төсөлд нэмж оруулах саналгүй болно.

ДАРГА *Б.САРАНЧИМЭГ*

160620154

⁷ "Төрийн аудитын байгууллага тухайн жилд Захиргааны ерөнхий хуулийн 103.3-т заасны дагуу төрийн албан тушаалтны төрд учруулсан хохирлыг төлүүлэх үүргийн биелэлтийн талаарх мэдээллийг жил бүр Үндэсний аудитын газрын цахим хуудсанд байршуулна"



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
САЛБАР ЗӨВЛӨЛ

21000. Чойбалсан, Дорнод аймаг
Утас: 7058-1681, 7058-3040, Факс: 7058-1681

2020.06.18 № 37
танай 2020.06.16-ны 386-т

Санал хүргүүлэх тухай

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ
ТАНАА

Б.Цогтсүх:

Танилцаж, дахин судалж
үзэхээр төслийн хам-
-руурт батлах ажил
гэсэн байгаа.

Бүт 5/19 2020

Таны 2020 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 386 дугаар албан бичгээр ирүүлсэн "Төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, хяналт тавих тухай хууль тогтоомжийн хэрэгжилт"-д хийсэн эрсдэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тайлангийн төсөлд төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар эрх зүйн орчин бүрдсэн ч төрд учирсан хохирлыг бүрэн тооцоогүй¹, төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаарх хяналт хангалтгүй² байна гэж тус тус тусгасан байна.

Мөн тайлангийн төслийн 6 дугаар нүүрт "Орон нутгийн хувьд салбар зөвлөл нь Төрийн албаны зөвлөлийн чиг үүргийг хэрэгжүүлэгч..." гэж тайлбарласан байна. Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйл /Улсын дээд шүүх энэ хуулийн 17.1-д заасан бүрэн эрхээс гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ/-ийн 17.3.1 дэх заалтад "Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах..." бүрэн эрхийг Улсын дээд шүүхэд тусгайлан олгосон байдаг тул Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар нь дээр дурьдсан /"Орон нутгийн хувьд салбар зөвлөл нь Төрийн албаны зөвлөлийн чиг үүргийг хэрэгжүүлэгч..."/ тайлбарыг хийж төв байгууллагын чиг үүргийг түүний салбар нэгжид хамаатуулах нь зохимжгүй юм.

Төрийн албаны тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1 дэх заалтад "Төрийн албаны төв байгууллага нь Төрийн албаны зөвлөл /цаашид "Зөвлөл"/", тус хуулийн 65.3 дахь заалтад "Зөвлөл нь хараат бус, бие даасан байгууллага бөгөөд ажлын алба, салбар зөвлөл, сургалт судалгаа, мэдээллийн нэгдсэн сангийн нэгжтэй байна" гэж тус тус тодорхой заасан нь Төрийн албаны төв байгууллага нь зөвхөн Төрийн албаны зөвлөл байх, харин салбар зөвлөл нь Төрийн албаны төв байгууллага буюу Төрийн албаны зөвлөлийн нэгжүүдийн нэг нь байхаар ялгамжтай хуульчилсан нь тус 2 байгууллага, салбар нэгжийн бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийн ялгаатай байдлыг харуулж байна.

1.Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажлын зохион байгуулалт, үйл ажиллагаа нь Төрийн албан зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын дагуу зохицуулагддаг бөгөөд тус журмын Гуравдугаар бүлэгт Салбар зөвлөлийн хэрэгжүүлэх чиг үүргийг тусгахдаа "төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, төрд учирсан хохирлыг тооцож ажиллах" чиглэлээр заагаагүй байна.

010520025

Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2 дахь заалтад “Төрийн албаны төв байгууллага шүүхийн шийдвэрийн биелэлтийн талаар бүртгэл хөтөлж, төрд учруулсан хохирлын нөхөн төлөлтөд хяналт тавьж, нөхөн төлөгдөөгүй тохиолдолд төрийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргана” гэж заасны дагуу төрд учирсан хохирлыг бүрэн тооцох, хохирлыг нөхөн төлүүлэх талаарх хяналт тавих ажил нь төрийн албаны төв байгууллага буюу Төрийн албаны төв зөвлөл эрх хэмжээний хүрээнд зохион байгуулах ажил юм. Мөн Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3.1.5 дахь заалтаар Салбар зөвлөлийг эрх хэмжээний хүрээнд шийдвэр гаргах, шийдвэрийн биелэлтийг хангуулан ажиллахаар заасан тул төрийн албаны төв байгууллага буюу Төрийн албаны зөвлөлд хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг Салбар зөвлөл хэрэгжүүлэх боломжгүй, энэ чиглэлийн мэдээлэл Салбар зөвлөлд хянагдан бүртгэгдэж, нэгтгэгддэггүй, өөрт олгогдоогүй чиг үүрэг болох төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаарх хяналт тавих ажлыг зохион байгуулах эрхгүй юм.

2.Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3.6 дугаар бүлэгт Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн хяналт тавих, аудит хийх ажлын хүрээг зохицуулсан бөгөөд үүнд Салбар зөвлөл нь хүний нөөцийн аудит, хүний нөөцийн бодлогын хэрэгжилт, албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрт болон төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавихаар тусгасан.

Харин Төрийн албаны тухайн хуулийн 50 дугаар зүйлийн 50.2 дахь заалтад “Төрийн албаны төв байгууллага буюу Төрийн албаны Зөвлөл шүүхийн шийдвэрийн биелэлтийн талаар бүртгэл хөтөлж, төрд учруулсан хохирлын нөхөн төлөлтөд хяналт тавих”-аар чиг үүргийг ялгамжтайгаар заасан.

Эдгээр үндэслэлээр Улсын Их Хурлын 2019 оны 17 дугаар тогтоолоор баталсан “Төрийн зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн 5.11 дэх заалт /Зөвлөл Салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, чиг үүрэг, үйл ажиллагааны хүрээ, ажиллах журмыг тогтоон мөрдүүлнэ/-нд тусгагдсан эрхийн хүрээнд Төрийн албаны төв байгууллага буюу Төрийн албаны зөвлөл 2019 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын дагуу Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөл нь шүүхийн шийдвэрийн биелэлтийн талаар бүртгэл хөтөлж, төрд учруулсан хохирлын нөхөн төлөлтөд хяналт тавих ажиллагааг хариуцан хийдэггүй тул төрд учирсан хохирлыг бүрэн тооцох, учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаарх хяналт боломжгүй болно.

Иймд “Төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, хяналт тавих тухай хууль тогтоомжийн хэрэгжилт”-д хийсэн эрсдэлийн аудитын тайлангийн төслийн 9 дүгээр нүүрт дурдсан “Аймгийн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд Төрийн албаны тухай хуулийн 50.1, 50.2 дахь заалтын дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээ байхгүй” гэх, 12 дугаар нүүрийн Дүгнэлтийн 4 дэх заалтад дурдсан “Төрийн албаны салбар зөвлөл нь хууль тогтоомжид заасан хяналтаа хэрэгжүүлж ажиллаагүй байна” гэх бичвэрүүдийг дахин нягталж, өөрчлөн найруулж өгнө үү.

ДАРГА



П.БАТ-ӨЛЗИЙ

ХАРИУ ТАЙЛБАР:

1. Тайлангийн төслийн 6 дугаар нүүрт орон нутгийн хувьд салбар зөвлөл нь Төрийн албаны зөвлөлийн чиг үүргийг хэрэгжүүлэгч гэсэн нь Төрийн аудитын газар хуулийн талаар тайлбар гаргасан биш бөгөөд Үндэсний хэмжээний байгууллагын хувьд орон нутаг дахь салбар байгууллага нь тухайн байгууллагын чиг үүргийг төлөөлөн хэрэгжүүлэх тухай нийтлэг ойлголтыг тусгасан.

2. Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл нь Төрийн албаны зөвлөлийн бүтцийн нэгж болохын хувьд Төрийн албаны тухай хуульд заасан төв байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх, төв байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх тухай салбар зөвлөлийн журмын нийтлэг үндэслэлд заасан байна. Тайлангийн төсөлд ч Төрийн албаны тухай хуулийн 50.1, 50.2 дахь заалтын дагуу авч хэрэгжүүлэх арга хэмжээг салбар зөвлөлийн ажиллах журмын хүрээнд тусгасан. Тухайлбал: Нэхэмжлэл гаргах нь төв зөвлөлийн чиг үүрэгт хамаарах ч нэхэмжлэл гаргах талаар санал хүргүүлэх нь салбар зөвлөлийн чиг үүрэгт хамаарч байна.

Иймд Төрийн албаны тухай хуулийн 50.1, 50.2 дахь заалт төв байгууллагад хамааралтай, салбар зөвлөлийн журамд төрд учруулсан хохирлын нөхөн төлөлтөд хяналт тавих талаар тусгагдаагүй гэсэн тайлбарыг бүрэн хүлээн авах боломжгүй гэж үзсэн тул тайлангийн төслийн 9 дүгээр нүүрт дурдсан бичвэрийн утгыг хэвээр үлдээж, харин хяналтыг шууд бие даан хэрэгжүүлэхгүй гэсэн тайлбарыг хүлээн авч, 12 дугаар нүүрт дурдсан дүгнэлтэд “Төрийн албаны салбар зөвлөлд Төрийн албаны тухай хуулийн 50.1, 50.2 дахь заалтыг хэрэгжүүлэх талаар зохион байгуулсан арга хэмжээ байхгүй байна.” гэсэн өөрчлөлт орууллаа.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар эрх зүйн орчин бүрдсэн ч төрд учирсан хохирлыг бүрэн тооцоогүй байна.
2. Төрд учруулсан хохирлын барагдуулалт 20.1 хувьтай байна.
3. Санхүүгийн хяналт, аудитын алба нь төрд учирсан хохирлыг буцаан төлүүлэх асуудлыг төлөвлөгөөт хяналт шалгалтын үед илэрсэн зөрчлийн хүрээнд шийдвэрлэж байгаа нь тус асуудалд тавих хяналтын үр нөлөөг бууруулж байна.
4. Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд Төрийн албаны тухай хуулийн 50.1, 50.2 дахь заалтыг хэрэгжүүлэх талаар зохион байгуулсан арга хэмжээ байхгүй байна.
5. Төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх талаарх хуулийг хэрэгжүүлэх байгууллагууд нэгдсэн нэг мэдээлэл, арга зүй, ажлын уялдаа дутмаг байна.

Аудитаар нийт 57.1 сая төгрөгийн зөрчил илэрснээс 11.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэх саналыг ҮАГ-т хүргүүлж, 45.3 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгч ажиллалаа.

ДЭЭД ШАТНЫ БАЙГУУЛЛАГАД ХҮРГҮҮЛЭХ САНАЛ:

Үндэсний аудитын газарт:

Аудитаар илэрсэн шүүхээс ажилгүй байсан хугацааны нөхөн олговорт төсвөөс олгосон 11.8 сая төгрөгийн зөрчил нь улсын төсөвт байгууллагуудын ТЕЗ-дийн дотоод аудитын нэгжид хамаарахаар байгаа тул асуудлуудыг шийдвэрлэх талаар холбогдох газарт уламжлуулах.Үүнд:

1. Дорнод Их сургууль 2.5 сая төгрөг
2. Стандарт, хэмжил зүйн хэлтэс 6.2 сая төгрөг
3. Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс 3.1 сая төгрөг

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дараах албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дарга П.Бат-Өлзийд:

1. Төрийн албаны тухай хуулийн 50.2, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам-ын 1.2, 3.4.3, 3.6.4 дэх заалтуудыг хэрэгжүүлж, төрд учирсан хохирлыг тооцох, нөхөн төлүүлэх талаар тодорхой арга хэмжээ зохион байгуулж ажиллах
2. Төрд учирсан хохирлыг төлүүлэх талаарх ажлын арга зүй, уялдаа холбоог сайжруулах.

Санхүүгийн хяналт, аудитын албаны дарга Б.Саранчимэгт:

3. Төрд учирсан хохирлыг буцаан төлүүлэх үүргээ бүрэн хэрэгжүүлж, хяналтын үр нөлөөг сайжруулах.

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг 2020 оны 11 дүгээр сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2020 оны 06 сарын 15 өдөр

Дугаар 12

Чойбалсан хот

Эрсдэлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/207 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 2.4 дэх заалт, 2016 оны А/92 тоот тушаалаар батлагдсан “Гүйцэтгэлийн аудитын журам”-ын 12.40 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, хяналт тавих тухай хууль, тогтоомжийн хэрэгжилт”-д хийсэн эрсдэлийн аудитын тайланг баталсугай.

2. Аудитын тайланг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дарга П.Бат-өлзий, Санхүүгийн хяналт, аудитын албаны дарга Б.Саранчимэг нарт хүргүүлсүгэй.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор Д.Нармандах-д даалгасугай.



Б.БОЛОРТУУЛ

110219107

ДОРНОД АЙМАГ, ХЭРЛЭН СУМ, 7-Р БАГ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
2-Р БАЙР, 1,2 ДАВХАРТ
УТАС: +976 7058-4203, 7058,-4204, 7058-4207,
И-МЭЙЛ: DORNOD@AUDIT.GOV.MN, ВЭБ САЙТ: WWW.AUDIT.MN